



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022 /96/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас:70342580 Цахим хаяг:ankhbayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:70342716 Цахим хаяг:enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Одбаясах Утас:99889486 Цахим хаяг: odbayasakhe@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Аудитын санал дүгнэлт:



ХУТАГ-ӨНДӨР СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>58,845,475.75</u>	<u>24,382,144.35</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	210,000.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	210,000.00	00.00
3121	Төгрөг	210,000.00	00.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	210,000.00	00.00
33	АВЛАГА	15,360,000.00	7,600,000.00
335	Бусад авлага	15,000,000.00	7,600,000.00
3351	Байгууллагаас авах авлага	15,000,000.00	7,600,000.00
336	Зээлийн авлага	360,000.00	00.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	360,000.00	00.00
33611	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	360,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	43,275,475.75	16,782,144.35
351	Түүхий эд материал	00.00	00.00
354	Хангамжийн материал	43,275,475.75	16,782,144.35
35410	Бичиг хэргийн материал	293,000.00	310,000.00
35420	Аж ахуйн материал	22,123,149.75	8,980,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	2,367,500.00	3,348,125.00
35450	Барилгын засварын материал	4,817,000.00	00.00
35460	Хүнсний материал	11,116,826.00	4,144,019.35
35470	Бусад хангамжийн материал	2,558,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>646,169,054.45</u>	<u>637,414,987.59</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	646,169,054.45	637,414,987.59
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	616,233,054.43	607,544,987.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	714,327,275.20	747,647,995.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		227,761,011.02	252,587,809.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00

39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,780,705.00	75,993,486.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,528,086.92	-31,796,706.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,978,851.95	46,595,570.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,514,432.02	-14,470,395.91
39214	Бусад үндсэн хөрөнгө	95,141,029.30	67,955,839.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-28,628,094.45	-33,323,809.46
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	00.00
39217	Ном	1,436,817.39	1,530,817.39
393	Биет бус хөрөнгө	29,936,000.02	29,870,000.05
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-43,999.98	-109,999.95
39303	Бусад биет бус хөрөнгө	29,100,000.00	29,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>705,014,530.20</u>	<u>661,797,131.94</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>705,014,530.20</u>	<u>661,797,131.94</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	705,014,530.20	661,797,131.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	531,559,751.60	531,559,751.60
51101	Өмч: - төрийн	531,559,751.60	531,559,751.60
512	Хуримтлагдсан үр дүн	-	-
51210	Өмнөх үеийн үр дүн	166,413,474.25	209,630,872.51
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-43,217,398.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	339,868,252.85	339,868,252.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>705,014,530.20</u>	<u>661,797,131.94</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	722,425,040.00	727,657,933.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	722,065,040.00	726,977,933.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,950,740.00	32,624,370.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,950,740.00	32,624,370.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,950,740.00	32,624,370.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	712,114,300.00	694,353,563.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	660,538,600.00	643,875,300.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	51,575,700.00	50,478,263.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	360,000.00	680,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	360,000.00	360,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	360,000.00	360,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	320,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	260,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	60,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	729,281,773.46	729,993,115.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	729,281,773.46	729,993,115.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	654,853,950.65	684,675,593.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,011,669.19	481,124,814.00
210101	Үндсэн цалин	315,819,776.62	346,840,626.00
210102	Нэмэгдэл	81,359,935.02	86,686,877.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	52,831,957.55	47,597,311.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,738,090.00	62,277,018.03
210201	Тэтгэврийн даатгал	38,333,238.00	43,635,932.18
210202	Тэтгэмжийн даатгал	4,509,792.00	4,829,754.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,604,474.00	3,863,803.33
210204	Ажилгүйдлийн даатгал	842,503.00	904,321.51
210205	Эрүүл мэндийн даатгал	8,448,083.00	9,043,206.97
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,631,924.00	48,377,638.00
210301	Гэрэл, цахилгаан	5,028,224.00	5,765,863.00

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	38,961,700.00	42,537,775.00
210303	Цэвэр, бохир ус	642,000.00	74,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,380,330.00	8,193,960.00
210401	Бичиг хэрэг	2,587,551.00	634,950.00
210402	Тээвэр, шатахуун	1,410,000.00	1,214,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	386,057.00	641,080.00
210404	Ном, хэвлэл	00.00	27,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,606,571.00	917,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,390,151.00	4,759,230.00
2105	Нормативт зардал	37,436,405.50	25,131,264.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	123,250.00	126,350.00
210502	Хоол, хүнс	35,587,155.50	23,789,914.15
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,726,000.00	1,215,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,157,910.00	1,321,100.00
210604	Урсгал засвар	3,157,910.00	1,321,100.00
2107	Томилолт, зочны зардал	372,000.00	193,200.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	372,000.00	193,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,154,920.00	1,388,208.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	938,920.00	1,388,208.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,970,701.96	56,668,391.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,092,840.00	1,701,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,826,200.00	2,629,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,051,661.96	52,337,541.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,427,822.81	45,317,522.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	880,000.00	894,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	880,000.00	894,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	44,423,522.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	44,423,522.47
213304	Хөрөнгийн	00.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	73,547,822.81	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,547,822.81	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-6,856,733.46	-2,335,182.99
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	14,585,340.00	00.00
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	00.00	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	14,585,340.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	50,175,362.20	40,882,215.27
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,140,247.15	7,455,555.52

225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	41,035,115.05	33,426,659.75
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-35,590,022.20	-40,882,215.27
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-42,446,755.66</u>	<u>-43,217,398.26</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	531,559,751.60	339,868,252.85	-153,897,503.49	00.00	717,530,500.96
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	531,559,751.60	339,868,252.85	-153,897,503.49	00.00	717,530,500.96
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	18,548,192.85	00.00	18,548,192.85
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	531,559,751.60	339,868,252.85	-166,413,474.25	00.00	705,014,530.20
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	531,559,751.60	339,868,252.85	-166,413,474.25	00.00	705,014,530.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	531,559,751.60	339,868,252.85	-166,413,474.25	00.00	705,014,530.20
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-43,217,398.26	00.00	-43,217,398.26
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	531,559,751.60	339,868,252.85	-209,630,872.51	00.00	661,797,131.94

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>728,959,640.00</u>	<u>699,883,417.50</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>728,599,640.00</u>	<u>698,843,417.50</u>
120	Нийтлэг татварын бус орлого	14,585,340.00	4,489,854.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,585,340.00	4,489,854.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,585,340.00	4,489,854.50
122	Тусламжийн орлого	1,900,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	1,900,000.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	712,114,300.00	694,353,563.00

123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	660,538,600.00	643,875,300.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	51,575,700.00	50,478,263.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	360,000.00	1,040,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	360,000.00	720,000.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	360,000.00	720,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	320,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	260,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	60,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	711,075,740.00	676,036,417.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	711,075,740.00	676,036,417.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	636,287,917.19	630,718,895.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	451,911,669.19	481,124,814.00
210101	Үндсэн цалин	315,819,776.62	346,840,626.00
210102	Нэмэгдэл	81,359,935.02	86,686,877.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	54,731,957.55	47,597,311.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,738,090.00	62,277,018.03
210201	Тэтгэврийн даатгал	38,333,238.00	43,635,932.18
210202	Тэтгэмжийн даатгал	4,509,792.00	4,829,754.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,604,474.00	3,863,803.33
210204	Ажилгүйдлийн даатгал	842,503.00	904,321.51
210205	Эрүүл мэндийн даатгал	8,448,083.00	9,043,206.97
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,085,424.00	49,278,263.00
210301	Гэрэл, цахилгаан	5,028,224.00	5,765,863.00
210302	Түлш, халаалт	39,215,200.00	43,438,400.00
210303	Цэвэр, бохир ус	842,000.00	74,000.00
210304	Байрны түрээс	00.00	00.00

210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,154,628.00	6,937,380.00
210401	Бичиг хэрэг	500,000.00	560,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,030,000.00	1,029,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	386,057.00	481,080.00
210404	Ном, хэвлэл	00.00	35,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,300,000.00	1,760,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,938,571.00	3,071,150.00
2105	Нормативт зардал	41,847,175.00	22,653,162.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	123,250.00	126,200.00
210502	Хоол, хүнс	40,008,225.00	21,306,962.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,715,700.00	1,220,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	898,370.00	1,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	898,370.00	1,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	372,000.00	193,200.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	372,000.00	193,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,992,360.00	1,388,208.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,776,360.00	1,388,208.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,288,201.00	5,666,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,601,450.00	2,394,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,686,751.00	3,272,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,787,822.81	45,317,522.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	880,000.00	894,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	880,000.00	894,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	44,423,522.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	44,423,522.47
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	73,907,822.81	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,907,822.81	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,883,900.00	23,847,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,673,900.00	24,057,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,673,900.00	24,057,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,673,900.00	24,057,000.00
220001	Барилга байгууламж	00.00	00.00
221001	Их засвар	00.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	17,673,900.00	23,963,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	94,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-17,673,900.00	-24,057,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	210,000.00	-210,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	210,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	210,000.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00	00.00	694,777,100.00	630,572,895.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	00.00	694,777,100.00	630,572,895.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	00.00	693,877,100.00	629,678,895.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	00.00	490,082,100.00	481,124,814.00
210101	Үндсэн цалин	00.00	00.00	344,849,000.00	346,840,626.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00	96,128,500.00	86,686,877.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00	00.00	00.00
210104	Урамшуулал	00.00	00.00	49,104,600.00	47,597,311.00

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	00.00	66,251,100.00	62,277,018.03
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	46,647,800.00	43,635,932.18
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	4,918,800.00	4,829,754.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	3,902,700.00	3,863,803.33
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	980,100.00	904,321.51
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	9,801,700.00	9,043,206.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	00.00	49,701,800.00	49,278,263.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	00.00	5,698,100.00	5,765,863.00
210302	Түлш, халаалт	00.00	00.00	43,603,700.00	43,438,400.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	00.00	400,000.00	74,000.00
210304	Байрны түрээс	00.00	00.00	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	00.00	25,179,800.00	6,617,380.00
210401	Бичиг хэрэг	00.00	00.00	500,000.00	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00	1,030,000.00	1,029,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	00.00	587,500.00	481,080.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	137,500.00	35,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	1,500,000.00	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00	21,424,800.00	3,071,150.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00	00.00	00.00
2105	Нормативт зардал	00.00	00.00	49,343,200.00	22,653,162.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00	126,200.00	126,200.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00	47,988,800.00	21,306,962.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	1,228,200.00	1,220,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	00.00	5,200,000.00	1,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	4,000,000.00	00.00
210602	Тавилга	00.00	00.00	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00	00.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	00.00	1,200,000.00	1,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00	258,900.00	193,200.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00	00.00	00.00

210702	Дотоод албан томилолт	00.00	00.00	258,900.00	193,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	1,403,600.00	1,388,208.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	1,403,600.00	1,388,208.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	6456600.00	4946850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	2,179,700.00	1,674,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	4,276,900.00	3,272,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	900000.00	894000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	900,000.00	894,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	900,000.00	894,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00	00.00	24,057,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	00.00	00.00	24,057,000.00
220001	Барилга байгууламж	00.00	00.00	00.00	00.00
221001	Их засвар	00.00	00.00	00.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	00.00	00.00	23,963,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	00.00	00.00	94,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	50,901,800.00	4,489,854.50
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	50,901,800.00	00.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	50,901,800.00	00.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	00.00	00.00	4,489,854.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	00.00	4,489,854.50
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	210,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		260,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		260,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		260,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	260000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		260,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Одбаясах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хутаг-Өндөр сумын цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 781,357.1 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 3,906.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 2,344.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд дахин үнэлэн шинэчлэн тогтоогүй болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55,733.4 мянган төгрөгөөр буюу 7.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / мянган төгрөг /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Бараа материал	43,275.4	16,782.1	-26,493.3
Үндсэн хөрөнгө	927,644.6	969,703.7	-42,059.1
Нийт хөрөнгө	970,920.0	969,703.7	-42,059.1
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	717,530.5	661,797.1	-55,733.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	717,530.5	661,797.1	-55,733.4

Бараа материалын данс 16,782.1 мянган төгрөг болж 61 хувиар буюу 26,493.3 мянган төгрөгөөр буурсан. Тус онд Боловсрол шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтын газраас 1,738.3 мянган төгрөгийн тусгаарлах өрөөний багц, ариутгалын бодис багаж, хөгжмийн хэрэгсэл ирснийг бүртгэн авсан. Данс андуурч бусад үндсэн хөрөнгийн дээр бүртгэсэн байсан 89,80.0 төгрөгний зөөлөн эдлэлийг аж ахуйн материалруу шилжүүлэн бүртгэсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 969,703.7 мянган төгрөг болж 42,059.1 мянган төгрөгөөр буурсан нь данс бүртгэл зөрсөн үндсэн хөрөнгийг дотоод гүйгээгээр данс бүртгэл хоорон шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 661,797.1 мянган төгрөг болж 55,733.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 5,636.0 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан, нийт зардал өмнөх оноос 1,756.2 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар тус тус буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хутаг-Өндөр сумын цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 823,465.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 823,465.6 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 128,688.5 мянган төгрөгөөр бууруулан 694,777.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 643,875.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 50.47862 мянга нийт 699,883.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 655,459.9 мянган төгрөгийг зарцуулж, 44,423.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 698,843.4 мянган төгрөг буюу 100.6 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 62,277.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 49,278.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 6,617.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БСУГ-аас 260.0 мянган төгрөгийн ариутгалын зардал, 60.0 мянган төгрөгийн тендерийн баримт бичгийн үнэ нийт 320.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Хутаг-Өндөр сумын цэцэрлэг нь 2021 онд нийт 713,641.3 мянган төгрөгийн 145 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулснаас 1 мэдээллийг мэдээлэх хугацаа хоцроож, 713,641.3 мянган төгрөгийн 145 мэдээллийг ил тод байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжинд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43-р тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн 12-р зүйл, 14-р зүйлийн хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэсэн байна.	1	15,000.0	1	7,400.0	7,600.0

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй 6,730.0 төгрөгний авлага барагдуулж 9,770.0 мянган төгрөгний авлага барагдуулаагүй зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Залруулсан алдаа: Аудитаар хийгдсэн залруулга байхгүй болно.